



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
АЛБАН ДААЛГАВАР

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Сар шинийн баярыг угтаж хот нийтийн
аж ахуйн чиглэлээр шуурхай хэрэгжүүлэх
зарим арга хэмжээний тухай

Сар шинийн баяраар иргэдийн аюулгүй, ая тухтай шинэлэх нөхцөл, боломжийг бүрдүүлэх зорилгоор 2019 оны 01 дүгээр сарын 21-нээс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд дараах чиглэлийн арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр Улаанбаатар хотын Ерөнхий менежерээс дүүргүүдийн Засаг дарга нар болон хот нийтийн аж ахуйн ажил үйлчилгээ эрхэлдэг мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжүүдэд ДААЛГАХ нь:

1. Айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын ачилтын давтамжийг 2-3 дахин нэмэгдүүлэх, орон сууц, гэр хорооллын гудамж, үерийн хамгаалалтын далан суваг, тунгаагуур дотор үүссэн ил задгай хогийн цэгүүдийг цэвэрлэж, устгах, нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдал, нуухны шороог цэвэрлэх, авто замын зорчих хэсэг, түүний эгнээ болон ногоон байгууламжийг тусгаарласан төмөр болон тросон хайс, хашлага, нийтийн эзэмшлийн талбайд байршуулсан сандал, хогийн сав, бункер, хөшөө, баримал, авто замын босоо тэмдэг, хог ачиж цуглуулах үйлчилгээнд ажиллаж байгаа хог тээврийн автомашин зэргийг угааж цэвэрлэн, эвдрэл гэмтлийг засварлах, өнгө үзэмжийг сэргээж ажиллахыг “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ, “Улаанбаатар зам засвар, арчлалтын газар” ОНӨААТҮГ болон Дүүргүүдийн хог хаягдлын үйлчилгээний байгууллага, зам замын байгууламжийн цэвэрлэгээ хариуцсан мэргэжлийн байгууллагуудын удирдлагуудад тус тус;

2. Нийтийн тээврийн үйлчилгээнд ажиллаж байгаа үйлчилгээний том болон дунд оврын автобусны гадна болон дотор талын тоос шороо, тортогийг угааж цэвэрлэх, дотор заалны хэсгийн эвдэрч цоорсон сандал, бариул, эд зүйлсийг засаж сэлбэх, өнгө үзэмжийг сэргээх, нийтийн тээврийн үйлчилгээг иргэдийн зорчих хэрэгцээнд нийцүүлэн зохицуулах, нийтийн тээврийн эргэлтийн цагийн хуваарийг мөрдүүлж, байнгын хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Нийтийн тээврийн газарт тус тус;

•1110300001